

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

**2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхгава гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-28
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай	6
2.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай	7-8
3.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-28

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 01 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, С.Бямбацогт, Б.Батбаатар;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Оюун-Эрдэнэ, О.Номинчимэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Номтойбаяр.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2

Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулав.

Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 11 минутад хэлэлцэж дуусае

Гурав.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, мөн газрын мэргэжилтэн А.Золжаргал, Эх орончдын нэгдсэн намын дарга Г.Ганбат, Монголын Социал демократ намын төлөөлөл Ж.Сандуйжав, Гэр хорооллын хөгжлийн намын дарга Б.Батсүх, Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайхан, Иргэний зориг ногоон намын нарийн бичгийн дарга Ш.Мөнхжаргал, хуульч Ж.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Д.Энхтүвшин, Ж.Баярмаа, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайхан, Эх орончдын нэгдсэн намын дарга

Г.Ганбат, Монголын Социал демократ намын төлөөлөл Ж.Сандуйжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Амарсайхан, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 3

Бүгд: 18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 01 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн ирсэн байна. Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Тогмидын Доржханд гишүүн ирсэн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна. Хуралдаанд ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг та бүхэнд танилцуулъя.

Нэг.Байнгын хорооны тогтоол “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох”.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай. Үүн дотроо Цөмийн аюулгүй ажиллагааны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл,

3.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

4.Улс төрийн намуудын тухай хуульд дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Ингээд 3 дахь санал бол Улс төрийн намын тухай хууль, шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээр асуудал. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай” асуудлыг хэлэлцье.

Тайлбар дэд хорооны даргыг дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг нэр дэвшүүлж байгаа.

Дэд хорооны дарга нэр дэвшүүлсэн тухай асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Дэд хорооны нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу?

Алга байна.

Нэр дэвшүүлж дууслаа.

Нэр дэвшилттэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Үг хэлж дууслаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Цэнд овогтой Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар сонгох нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүнээс 12 гишүүн санал хураалтад оролцож, 85.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол байгаа шүү дээ.

Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, “Дэд хорооны даргыг сонгох тухай”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар сонгосугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй.

Тогтоолтой холбоотойгоор асуулт асуух гишүүд алга байна. Ингээд асуудлыг хэлэлцэж дууслаа. Сандаг-Очир гишүүнд амжилт хүсье.

14.06 цаг

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан байгаа.

Ингээд 3 асуулт байгаа. Санал хураалт явуулъя. 4 асуулт тээ.

1.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газрын газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 87.5 хувиар санал дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

3.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт .

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 81.3 хувиар санал дэмжигдлээ.

Амарсайхан гишүүний саналыг дэмжиж байгаа. Дэмжсэнээр протоколд тусгая. Санал дэмжигдлээ.

4.Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 81.3 хувиар санал дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

14.11 цаг

Гуравдугаар асуудалд оръё. Улс төрийн намуудын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэе.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгээ оруулъя.

Учрал сайд, Б.Солонгоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Н.Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, А.Золжаргал Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын газрын мэргэжилтэн, Г.Ганбат Эх орончдын нэгдсэн намын дарга, Ж.Сундуйжав Монголын Социал демократ намын төлөөлөл, Б.Батсүх Гэр хорооллын хөгжлийн нам, Ц.Гантулга Шинэ намын дарга, Б.Жаргалсайхан Бүгд найрамдах намын дарга, Ж.Гантуяа хуульч, Мөнхжаргал Иргэний зориг ногоон намын нарийн бичгийн дарга гэсэн ийм хүмүүс байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Учрал сайд танилцуулна. Учрал сайдын микрофоныг, микрофонд урьж байна.

Учрал сайнд ирцэд орсон уу? Орсон байна. Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан бөгөөд 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна. Тус хуульд зааснаар улс төрийн нам нь Үндсэн хуульт байгуулал ардчилсан тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд дотоод зохион байгуулалт үйл ажиллагаагаа ардчилсан зарчимд нийцүүлэн шинэчилж үндэсний хэмжээний бодлого дэвшүүлэн ил тод, хариуцлагатай ажиллах чиг үүргийг хүлээх болсон.

Иймд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд дотоод зохион байгуулалттай хуульд нийцүүлэн шинэчилж, намын дүрэм, хөтөлбөрөө илүү өргөн хүрээгээр тодорхойлж, үндэсний хэмжээний бодлогыг дэвшүүлж, Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд оролцон ажиллахад чиглүүлэх шаардлага үүссэн.

Энэхүү шаардлагыг харгалзан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд Шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ гэсэн хугацаа тогтоосон зохицуулалтыг хуульчилсан байдаг.

Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2024 оны 6 дугаар сард Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгууль зохион байгуулагдаж улс

төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулах, нэр дэвшигчдийг тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуульд оролцох, сонгуулийн үр дүнгээр Их Хурал шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах зэргээр сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал намын дүрэм, журмыг шинэ хуульд нийцүүлэх боломж хомс байсан.

Өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй нийт 37 нам байгаа бөгөөд тэдгээрээс 2024 оны Их Хурлын сонгуульд 22, орон нутгийн сонгуульд 12 нам, эвсэл тус тус оролцсон.

Намын дүрмээр гишүүдийн эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтцээс гадна намын удирдах дээд төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх болон хяналтын байгууллагыг байгуулах журам, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ болон намын салбар, бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг цогц байдлаар зохицуулахаар хуульчилсан.

Түүнчлэн намын дүрэм, хөтөлбөрийг шинэчлэхэд гишүүдийн оролцоо ил тод байдлыг хангах, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг баримтлах, мөн намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан.

Өөрөөр хэлбэл, намын дүрмийн гуравны нэгээс дээш хэмжээний өөрчлөлт оруулах асуудлыг намын анхан шатны бүх нэгжийг хуралдуулж, гишүүдийн оролцоог хангаж шаталсан хэлбэрээр санал авсны үндсэн дээр намын удирдах дээд байгууллагаас эцэслэн шийдвэрлэж Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр хуульд заасан.

Ийнхүү улс төрийн намын дүрмийн шинэчлэл нь гишүүдийн идэвх, оролцоог хангахыг шаардсан өргөн хүрээний өөрчлөлтийг хамарч байгаа тул хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө санхүү, зохион байгуулалт, төлөвлөлтийг шаардсан төдийгүй тодорхой шат дамжлага бүхий бэлтгэл ажлыг хангахгүйгээр шууд хэрэгжүүлэх боломжгүй асуудал үүсэж байна.

Намын бүтэц, дүрмийг ардчиллын зарчимд нийцүүлэн шинэчлэхэд намын бүтцийн байгууллагуудад жендерийн тэгш байдал, хүйсийн төлөөллийн оролцоо хуульд заасан хэмжээнд бүрдүүлсэн байх шаардлага мөн тавигдаж байна.

Гэвч энэхүү шаардлагыг богино хугацаанд хангахад ялангуяа Улсын Их Хуралд суудалгүй болон Улс төрийн намын тухай хуулийн 27.3-д заасан нөхцөлийг хангаагүй намуудын хувьд энэхүү шинэчлэлийг хуульд заасан хугацаанд хийж бүртгэлээ баталгаажуулах, жендерийн тэгш байдлыг хангасан бүрэлдэхүүнээр хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах боломж хязгаарлагдмал байна. Улс төрийн намын дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэн бүртгүүлэх хугацааг хойшлуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудад хандан Бүгд найрамдах нам, Шинэ нам, Эх орончдын нэгдсэн нам, Зүй ёс нам, Гэр хорооллыг хөгжүүлэгч нам, Монголын социал демократ нам, Үнэн ба зөв нам зэрэг улс төрийн намуудаас санал шаардлагыг ирүүлсэн.

Иймд улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, Үндсэн хуулийн суурь зарчим, жендерийн тэгш байдал, гишүүдийн оролцоог хангах хуулийн шаардлагад нийцүүлэн намын өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг нэг мөр

цогц байдлаар шинэчлэх боломжийг бүрдүүлэх, хангах зорилгоор Улс төрийн намын тухай хуулийн зөвхөн 2 дугаар зүйлд заасан өөрчлөлт буюу дүрэм, хөтөлбөртэй холбогдсон зохицуулалтыг тодорхой хугацаанд хойшлуулах хуулийн төслийг Засгийн газраас боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

Улс төрийн намын тухай хууль түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хуулийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн, Пүрэвдорж гишүүн. Хэн бэ?

Б.Пүрэвдорж: Ирцийнхээ дагуу. Бүгдэд нь энэ өдрийн мэндийг айлтгая.

Тэгэхээр 2024 оны сонгуулиар бүрдсэн парламент 126 гишүүнтэй болж, энэ хамтарсан засаг байгуулах ийм шийдэлд хүрсэн байгаа. Тэгэхээр яг энэ хамтарсан засаг байгуулах үед энэ ард түмний сонголтын дагуу тэр эрх баригч нь эрх баригчаа хийгээд, сөрөг хүчин нь сөрөг хүчнээ хийгээд энэ хамтарсан засагт орохгүй байх тухай хэвлэлийн бага хурлыг хийгээд эсэргүүцээд явж байсан.

Гэвч 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр энд бол 14 том төслийг хөдөлгөх, дэд 300 гаруй дэд төслийг хэрэгжүүлж энэ Монголынхоо хөгжил дэвшилд ялангуяа 2 нам 2 талдаа гарчхаад нэгнийхээ том төслийг улдан унагаадаг байсан тэр зүйлийг одоо шийдвэрлэх, Монголынхоо хөгжил дэвшлийн төлөө явах ийм боломжийг энэ хөтөлбөрт тусгасан тэр заалтуудаас би бас бас дэмжиж харсан.

Үүнийхээ дагуу яг энэ 2025 оны төсвийн тухай хууль ялангуяа жалганы хөрөнгө оруулалт тавихгүйгээр 38 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр ингэж орж ирсэн нь яг тэр мөрийн хөтөлбөртөө үнэнч байж, энэ том том төслүүдийг илүү урагшаа явуулах ийм хүсэл, эрмэлзэл байгаа нь одоо харагдсан байгаа.

Тэгээд үүнийхээ дагуу ч гэсэн бид нар хамгийн эхний төслийг явуулахаар Цөмийн энергийн хуулиа маш их өндөр хувиар буюу 97 хувиар ингэж парламентаар давуулна гэдэг бол маш тийм амжилтыг авчирч байна гэж харж байгаа.

Тийм учраас энэ Улс төрийн намын тухай хуулийг хэрэгжих хугацааг хойшилж, тодорхой хэмжээгээр хойшлуулж, ялангуяа жижиг намууд шууд энэ хурлаа хийх тэр боломж нь нэлээн хязгаарлагдмал байна. Энэ хуулийн дагуу 3 том нам л одоо гол асуудлаа шийдээд бүртгүүлэхээр ийм л нөхцөл байдалтай байгаа.

Тийм учраас бид нар олон намын системтэй энэ орныхоо хувьд бусад намуудынхаа тэр суудалтай болон суудалгүй намуудынхаа тэр хүсэлтийг харгалзаад бас энэ хуулийг бас хойшлуулах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тэгэхдээ энэ 2027 оны 8 сарын 1 гэдэг бол хэтэрсэн хугацаа байхгүй юу даа. Энэ дээр шууд, миний ойлгосноор манай намаас бас тодорхой санал авахгүйгээр шууд ингэж шийдэх нь буруу гэж би үзэж байгаа.

Тэгэхээр энэ хуулийг наашлуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, засаг тогтвортой байх нь, нам тогтвортой байх нь маш чухал. Нам тогтвортой байна гэдэг бол засаг тогтвортой байна гэсэн үг. Засаг тогтвортой байх юм бол Монгол Улсад хөгжилтэй томоохон төслүүдийг урагшлуулах ийм боломжийг нээнэ гэж харж байгаа.

Тийм учраас энэ хугацааг ялангуяа 2026 оны 1 сарын 1, түүнээс давуулахгүйгээр энэ хугацааг тавих талаар бас манай Их Хурлын гишүүд бас анхаарч ажиллана байх гэж би харж найдаж байгаа.

Тэгэхээр энэ хэтэрхий их хойшоо тавих ялангуяа намуудын доторх уур амьсгалыг их эвгүй сонин байдалд оруулах ийм нөхцөл байдал руу аваачих учраас яг энэ бас, дээрээс нь бид нар энэ Монгол Улсынхаа хөгжил дэвшлийг илүү авчрах тэр намын тогтвортой байдлыг хангах үүднээс энэ хугацааг тавьсан нь хамаагүй дээр л гэж би үзэж байгаа. Тэгээд үүний үр дүнд бас Монгол маань хөгжиж, дэвшиж тэр том төслүүд хөдөлсний үр дүнд энэ Монголчуудын амьдрал илүү сайжирч байвал хамгийн чухал байна гэдэг ийм саналтай байгаа гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдсэний дараагаар эн тэргүүнд өөрчлөгдөх ёстой, шинэчлэгдэх ёстой хуулиудын нэг бол Улс төрийн намын тухай хууль байсан.

Гэхдээ яах вэ энэ хууль маань бол нэг парламент дамжаад 2023 оны 7 сарын 7-нд батлагдсан. Улс төрийн намын тухай хууль ер нь улс төрийн тогтолцооны, улс төрийн харилцааны суурь хуулиудын нэг. Ардчилсан засаглалтай, ардчилсан дэглэмтэй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, олон ургалч үзэлтэй, олон намын тогтолцоотой ийм улсад гарцаа байхгүй нийгмийн харилцааг зохицуулах, улс төрийн харилцааг зохицуулах суурь хууль юм байгаа юм. Энэ ч үүднээс энэ хуулийн хэрэгжилт өөрөө хангагдаад явж байгаа.

Гэхдээ зарим зүйлүүд нь зарим зохицуулалтуудыг тодорхой нөхцөлтэйгөөр бас хэдийнээс хэрэгжихийг нь зохицуулсан ийм хууль байгаа гэдгийг хэлье. Энэ ч үүднээс энэ хуулийн ач холбогдлыг бид бүхэлдээ манай жишээ нь, улс төрийн тогтолцооны, улс төрийн засаглалын чухал хэрэгсэл, хэрэглэгдэхүүн гэж бас ойлгож байгаа шүү гэдэг билээ. Би ажлын хэсэгт манай бусад улс төрийн намуудын төлөөлөл байгаа учраас би ажлын хэсгийн бусад улс төрийн намын төлөөллөөс асуулт асууя гэж бодож байна л даа. Энэ дээр мэдээж хэрэг саяын тодорхой нөхцөлүүдийг, үндэслэлүүдийг бид сонслоо. Тэр ойлгож болно. Гарцаа байхгүй бас мэдээж хэрэг олон намуудын оролцоо бүхий улс төрийн үйл явц байх ёстой, улс төрийн тогтолцоо байх ёстой гэдэг үүднээс чухал ийм саналууд байна гэж ойлгож байна л даа.

Тэгэхдээ саяын хугацаатай холбоотой зүйлийг та бүхэн бас нарийн бас тооцсон байх, нарийн бас хоорондоо хэлэлцсэн байх гэж ойлгож байна. Тэгэхлээр би ажлын хэсгийн бусад намын төлөөллөөс тухайлбал, Бүгд найрамдах намаас Жаргалсайхан дарга сууж байна, энэ хугацааг хойшлуулах бодит нөхцөлийг нэгдүгээрт, хоёрдугаарт зайлшгүй шаардлагыг яг та бүхэн юу гэж үзсэн юм бэ гэдгийг та бүхний бас өөрсдийн чинь дуу хоолойноос сонсьё гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүний асуултад 9 номер Бүгд найрамдах намын дарга Жаргалсайхан хариулъя. 9 номерын микрофон.

Б.Жаргалсайхан: Энэ өдрийн мэндийг хүргэе бүгдэд нь.

Тэгэхээр олон юм байна л даа улс төрийн нам гэдэг ажил, амьдралын дадлага, туршлага, өнөөдрийн нийгмийн байдал, улс төрийн байдал, та бүгд ч гэсэн төсвөө хэлэлцэж байгаа, шинэ жил болох гэж байна, оны эцэс болох гэж байна энэ бүх юм давхцаж байна. Сая энэ өнгөрсөн жил бид нарт их хүнд туссан. Жижиг нам гэж тэгэхээр чинь би ч өөрөө ийм уртыг хэлэх үү тэгээд жижиг болчихоор ч муухай юм, яршиг гудамжны намууд л гэхээс. Гудамжны намуудад их хүнд туслаа сонгууль. Бид нар чинь өөрсдийнхөө бор зүрх гэдэг шиг өдөр, шөнөгүй гүйж явсан, асар их зардал гарсан, тэгээд байж байтал орон нутгийн сонгууль гээд л яваад өгч байна.

Ингээд сонгуулиас сонгуулийн хооронд санхүүгийн зардал гарсан, төр төсвөөс 1 төгрөг ч аваагүй, одоо ингээд энэ намын хууль гээд тэгэхээр чинь бид нар орон нутгаар явах хэрэгтэй байна, гишүүддээ танилцуулж энэ хууль, журам, дүрэм ингээд намаа шинээр, намын хурлаа хуралдах хэрэгтэй байна, шинээр бүртгүүлэх хэрэгтэй байна гээд ингээд асар олон ийм ажлууд гарах нь. Зардлууд ч гэсэн их гарах нь. Бид нарт тийм боломж алга.

Дээр нь өнөөдөр энэ намын хуулийг хэлэлцэж яах гээд байгаа юм тэр төсвөө хэлцэл дээ, энэ чинь өөр зөндөө ажил байхад ямар одоо Их Хурлын сонгууль болох гэж байгаа биш тийм, дахиад ямар орон нутгийн сонгууль хийх гэж байгаа биш нэг хэсэгтээ ингээд 4 жил завсарлана.

Тийм учраас бид нарт хангалттай цаг, хугацаа байна гэж үзэж байгаа. Тэгээд энийг хойшлуулаад өгөөч гэж хүсэж байгаа хэрэг. Тэр намын дарга энэ хууль хэрэгжих юм бол ингээд намын даргын сонгуультай ажил эхлэх юм байна ч гэдэг юм уу ингээд л нэг юмыг бужигнуулж байж л санаа нь амрах гээд байх шиг байгаа юм. Хэн ч намын дарга болсон яадаг юм ер нь. Тэрийг улс төр болгоод л ингээд л дэмий юм яриад л, хов жив болгоод л.

Тэгээд би сая Оюун-Эрдэнэтэй таарсан юм л даа Ардын намын даргатай, үгүй энэ Сонгуулийн хуулиа ингээд өөрчлөөд өгөөч бид нар амжихгүй ээ, тийм боломж, санхүүгийн энэ ажлыг улс төрийн ажил хийх бид нар тийм боломж одоохондоо алга байна. Энийг жоохон хойшлуулаад өгчих л дөө энэ чинь ямар өнөө маргаашдаа үхчих гэж байгаа биш энэ чинь, өөр зөндөө л хийх ажил байгаа байлгүй дээ улс төрийн.

Тийм учраас бид нарын энэ хүсэлтийг бас харгалзаж үзээрэй ялангуяа Ардчилсан намынхан тийм. Тэгээд бид нар хэрвээ яг өнөө маргаашгүй энэ хуулиар чинь явах юм бол бид нар тэгээд намгүй үлдэнэ гэсэн үг. Тийм юм байна лээ.

Очоод л шүүх дээр гацчих юм байна лээ. Яагаад гэхээр тэр олон хүний гар хөлийн үсэг, бүртгэл ингээд олон шалгуур даваатай юм байна лээ тэр хууль, журмыг чинь ингээд сайн үзэх юм бол. Тийм учраас бид нар одоохондоо энийг үнэхээр хийх боломж алга. Тийм ухаас энийгээ хойшлуулж өгөөч эрхэм Их Хурлын гишүүдээ гэж хүсэх гэсэн юм.

Тэгээд та нар алддаг шүү. Дараа нь юу гээд төсвийнхөө хуулийг хэлэлцээд л, ярилцаад л байсан. Алдсан шүү дээ тэгээд л Ерөнхийлөгч нь ирж хориг тавьж байж нэг юм ухаарцгаасан. Маргалдаад л байсан яг тэрэнтэй адилхан энэ сонгуулийн энэ намын хуулийг бас тэгэв ээ та нар ухаантай дүр эсгээд зүгээр л хойшлуулчих. Хэл ам хийхгүй тэр хэн нь намын даргаа хэн нь солих, солихгүй энд ерөөсөө хамаа байхгүй тэгж бодож байгаа шүү тэгээд. Харин Ардын намын намын дарга бол дэмжиж байна. Гантөмөр даргыг бас хашир хүн Японд сурч байсан юм болохоор бас мэргэн санаандаа бодоод хойшлуулах байлгүй дээ албан ёсоор. Тэгээд намынхаа гишүүдтэй бас сайн хэлэлцэж ярилцаад улс төржүүлэлгүй энэ намын хуулиа хойч үедээ, бид нар.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 24 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ гээд 2024 оны 7 сараас, 7 сарын 1-ээс хойш 6 сарын хугацаанд гэж байгаа шүү дээ. Тэгээд энийг хойшлуулаад 27 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор гэж хугацаа гаргаж байгаа. Энэ хугацааг л танаас асуух шиг боллоо сая. Болж байгаа юм уу, үгүй юү энэ 27, 8 чинь, 27 оны 8 сар гэдэг нь?

9 номерын микрофон Жаргалсайхан Бүгд найрамдах намын дарга.

Б.Жаргалсайхан: Хамгийн эцсийн хугацаа нь л 27 байхгүй юу. Тэгээд намууд хэлэлцэж, ярилцаж байгаад тэр дундаа хэзээ нь чи энэ хуулиа яавал зүгээр юм болоо л гэж бодсон юм. Үнэндээ дахиад энэ улс төрийн ажил нэг хэсэгтээ завсарлахгүй бол ажил, амьдрал хэцүүдлээ, мөнгө төгрөг, хөрөнгө мөнгө ч хэцүүдлээ хөөе.

Ж.Бат-Эрдэнэ: Уг нь тэгээд амжаад хийвэл хийх ч хугацаа ч байгаа л даа. За яах вэ. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Энэ хуулийн шинэчлэлийг дэмжиж байгаа, өөрчлөлтийг. Улс төрийн намуудын дотоод үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай болгох, нийгмийн бодит шаардлага байгаа нь үнэн. Бас энэ бодитой.

Гэхдээ нийт намын энэ дүрэм, журам, хөтөлбөр болон зохион байгуулалтын өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд хүргүүлэх хугацааг сунгах нь бодитой нөхцөл байдалтай нийцнэ гэж үзэж байгаа юм. Сая бас зарим гишүүд хүмүүс ярьж байна. Бид чинь ингээд л Улсын Их Хурлын сонгууль, орон нутгийн сонгууль, тэгээд л Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль гээд л бүтэн 4, 5 жил л улс төрийн асуудал ярьсаар, улс төржсөөр сонгуулийнхаа ард гарлаа.

Тэгээд дуусаагүй байтал арай гэж хамтарсан Засгийн газар байгуулаад улс орны үндсэн язгуур эрх ашигт нийцсэн бодлогын асуудлуудаа бодитой ажлуудаа шийдвэрлэ гээд явахаар намууд хуралдана ингэнэ гээд нэг хэсэг нь хийж байсан шинэчлэлээсээ ухралт болох гээд байна л даа. Байдаг 2, 3 хүн Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам гэдэг намууд бас харьцангуй хүн, хүч, бодлого институтийн түвшинд хүрсэн гээд ялгаатай байгаа. Нөгөө хэдэн намууд нь яг сая

энэ Жаргалсайхан даргын хэлж байгаа шиг энэ улсын ардчилал, шинэчлэлийн бодлого, улс төрийн үйл ажиллагаа, иргэний эрх чөлөө, дуу хоолойгоо илэрхийлэх гэдэг бүх зүйлүүдээс чинь энэ хугацаанд арчигдах ийм эрсдэл үүсэж байна.

Тэгэхээр энэ аль аль талынхаа бодитой бөгөөд нээлттэй оролцоог бий болгох, дотоодын улс төрийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээнд нийцүүлсэн энэ намуудыг шинээр төлөвшүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай. Ялангуяа энэ намууд ч их, бага хурлаа хийгээд, зохион байгуулалтаа хийнэ гэхээр энэ чинь цаг хугацааны хувьд дүрэм, хөтөлбөр шинэчлэх, зохион байгуулалтаа бодитой өөрчлөлт оруулах гээд олон үе шаттай ийм ажлууд явдаг.

Тэгээд дахиад нам улс төр шинэчилж, төр төлөвшиж, улс төр шинэчлэгдэх биш ухрах ийм эрсдэл рүү орох учраас энэ намуудын дотоод засаглал, ил тод байдлыг бас илүү хариуцлагатай болгох, зөвхөн энэ хууль хэрэгжүүлэх төдий биш улс төрийн орчин, тэгээд цаашаа иргэдийн энэ улс төрийн намд итгэх итгэлийг хүртэл сэргээхтэй холбоотой нарийн ширийн асуудлууд их байгаа учраас энэ хугацааг зайлшгүй харгалзаж, тэр 27 он оны 8 сарын 1 гэх нь зөв байх.

Ер нь энэ намууд өөрсдөө хуулийн өөрчлөлт шинэчлэлүүд, намын энэ зохион байгуулалтаас гадна үзэл бодлоо шинэчлэх, тодотгох ч шаардлагууд байгаа байх. Үйл ажиллагаа дотроо илүү зохион байгуулалттай болох ч асуудлууд бий. Анхан, дунд шатынхаа удирдлага, зохион байгуулалтыг ил тод, нээлттэй болгох асуудлууд бий гээд яриад байвал зөндөө зүйлүүд бий.

Тэгээд энэ асуудлуудыг харгалзаж үзээд энэ хуулийн өөрчлөлтийг хийгээд яв.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Мөнхбаатар гишүүн. Мөнхбаатар гишүүний.

Л.Мөнхбаатар: Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах бас зайлшгүй практик шаардлага бий болоод байна. Энэ оны 2024 оны л 7 сарын 7-ны өдрөөс хойш 6 сарын хугацаа гэж тоолох юм бол энэнээс, энэний өмнө Дээд шүүхэд бүртгүүлээгүй дүрмээ, улс төрийн намын хуулийн үзэл баримтлалд нийцүүлээгүй тохиолдолд бас хууль зөрчих ийм асуудал үүснэ.

Тийм учраас энийг зайлшгүй богино хугацаанд шийдвэрлэх шаардлага бий болоод байна. Ер нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 нам байгаа. Түүний 22 нам нь Улсын Их Хурлын сонгуульд оролцсон. Эдгээр намууд 37 намын хувьд бүгдээрээ бүх шатныхаа хурлаар уг дүрмийнхээ төслийг хэлэлцүүлж, төлөөлөх байгууллагынхаа дэд хурлыг хийх ёстой. Ингэж байж дүрмээ баталж, шинэчилж батлуулж өгөөд 30 хоногийн дотор бүртгүүлэх ийм үүрэг хүлээж байгаа юм.

Тэгэхээр энэ хугацаанд ингээд одоо 12 сар болж байна. Ингээд энэ богино хугацаанд бол амжихааргүй байгаа нь харагдаж байна. Тэгэхээр бол хуулийн хугацааг, дагаж мөрдөх хуулийн хугацааг хойшлуулж, улс төрийн намууд дүрмээ шинэчлэн батлуулж, улсын ... бүртгүүлэх энэ боломжийг нь олгох нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Ер нь яах вэ юу байгаа юм, хугацааны хувьд бас 2027 оны 8 сар гээд тавьсан, хууль санаачлагчид ингэж оруулж ирсэн байна. Зарим Улсын Их Хурлын гишүүд бас хугацаан дээрээ эргэж ярих боломж байгаа юу гэдэг зүйлийг ярьж байна.

Ингэхээр хугацааны хувьд бол энэ өнөөдөр бол хэлэлцэх эсэхээ шийдэж байна, чуулганаар хэрвээ хэлэлцэхийг нь дэмжсэн тохиолдолд ажлын хэсэг гарч, Төрийн байгуулалтын байнгын хорооноос ажлын хэсэг гарч ажиллах нь зүйтэй. Ажлын хэсэг дээрээ энэ тодорхой хойшлуулж байгаа хугацаан дээрээ бол 2 талаасаа ярилцаад шийдвэрлэх ийм боломж байгаа гэж харж байгаа гэдгээ бас хэлье.

Нөгөөтээгүүр бас хууль санаачлагчаас бас зүйлийг бас тодруулж асуух нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ бол санаачилж байгаа санаачлагч нь Засгийн газар хэдий боловчиг улс төрийн олон намууд шаардлага өгсөн гэж байгаа. Тэр шаардлагынхаа бас агуулга албан бичгийг бас танилцуулах нь зүйтэй. Эдгээр намуудын шаардлагын дагуу энэ бололцоог олгох талаар хуулийг Засгийн газар санаачилсан гэж ойлгож байгаа. Ер нь товчхон хэлэх юм бол хэлэлцэх эсэхээ хэдүүлээ шийдээд явчихъя. Үүний дараа ажлын хэсэг гаргаад хугацаан дээрээ яриад явахад бүрэн боломжтой гэдгийг хэлье гэж бодож байгаа.

Монгол Ардын намын хувьд 4 жил тутам намынхаа Их Хурлыг хийдэг, дүрмээ шинэчлэн баталдаг, улс орныг хөгжүүлэх хөтөлбөрүүдээ угаасаа гаргадаг ийм нам. Монгол Ардын нам бол ирэх онд хуралдахаар бүх бэлтгэл ажлуудаа хангаад явж байгаа. Бусад 36 нам маань мөн Их Хурлуудаа хийж энэ дүрмийнхээ шинэчлэлийг Дээд шүүхэд бүртгүүлэх энэ арга хэмжээг авна гэдэгт итгэл.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Энхтүвшин дарга, Энхтүвшин гишүүн. Аасуулт Учрал сайд, Учрал сайд.

Н.Учрал: Монгол Улсын Засгийн газарт парламентад суудалгүй намуудаас энэ хуулиудын зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулаач гэдэг хүсэлтийг бас удаа дараа гаргасан. Тэгээд түрүүн бас би та бүхэнд энэ намуудыг дурдлаа. Одоогоор 9 улс төрийн намаас яг албан ийм хүсэлт ирээд байгаа. Тэгээд яг үүн дотор бол тодорхой хэдхэн үндэслэлийг шаардаж байгаа. Улс төрийн намуудын хувьд энэ Ерөнхийлөгчийн санаачилж өнгөрсөн парламентын үед батлагдсан Улс төрийн намын хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ бол үнэхээр энэ улс төрийн намуудын хувьд институт болж бүрдэхэд нийгэмд бас шинэ соёлыг бүрдүүлэхэд бас тодорхой хувь нэмрээ оруулж байгаа хууль мөн.

Тийм учир бас тэр нээлттэй байдлыг хангуулах, цахим бүртгэлээ хийх, дансаа шилэн болгох, идэвх, оролцоо, гишүүдийнхээ идэвх оролцоо, тэр дэргэдэх төрийн бус байгууллагуудын статусыг ойлгомжтой болгох, дэргэдээ тэр бодлогын судалгааны хүрээлэн байгуулах, хөтөлбөрөө үнэлэх гээд ийм шинэчлэлийг дагуулсан заалтууд, ялангуяа энэ хуулиар анх удаа дэмжигч гишүүдийн ийм статус бий болж байгаа. Эдгээрийг хэрэгжүүлээд явна 7 дугаар сарын 1-ээс 6 сарын хугацаанд.

Гол нь дагаж мөрдөх журмын хууль дээр байгаа 5 зүйлээс 2 дугаар зүйлийг л тодорхой хугацаанд хойшлуулж өгөөч. Яагаад гэхээр энэ нь өөрөө дүрмийн өөрчлөлт, дүрмийн өөрчлөлтөө шинээр бүртгүүлэх, хөтөлбөртэй холбоотой заалтууд байгаа юм.

Яагаад вэ гэхээр ерөөсөө үндэслэлүүдээрээ нэгд энэ удаа Их Хурал орон нутгийн шат шатны сонгууль явагдлаа. Ингээд 1 дүгээр сарын 1 гэхэд энэ бүртгэл Дээд шүүхэд бүртгэлээ явуулах хугацаа хаагдчих юм байна. Тэгэхээр бид нар бүх

шатны гишүүдээсээ дүрмийнхээ өөрчлөлтийн саналыг авч чадахгүй байна. Дээрээс нь дүрмийн өөрчлөлтийн гуравны нэгээс илүү нь өөрчлөгдөж байгаа тохиолдолд заавал удирдах дээд байгууллага буюу Их Хурлаа хийх шаардлага байна. Тийм учраас цаг хугацааны хувьд ийм бололцоо байхгүй байна.

Дээрээс нь шат шатын байгууллагууд дээр хүйсийн байдал буюу жендерт чинь 40 хувийг ханга гээд байгаа байхгүй юу. Тэр 40 хувийг хангуулсан бүх түвшний удирдах байгууллагуудыг шинээр бүрдүүлнэ гэдэг бол бид нарт бэрхшээлтэй байна гэдэг ийм хэд хэдэн үндэслэлийг энэ бичгүүд дээрээ дурдсан байгаа.

Тийм учраас зөвхөн тэр дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл буюу шинээр бүртгүүлэхтэй холбоотой үүсэж байгаа харилцааг л тодорхой хугацаагаар хойшлуулъя. Бусад улс төрийн намын хуулийн үндсэн зүйл, заалтууд хэрэгжээд явна гэдгийг бас хэлэх ёстой. Тэрнээс бусад асуудлын хувьд буюу ил тод байдлыг хангуулах гээд байгаа шилэн данс хөтлөх ч гэдэг юм уу энэ бүх зүйл хэвээрээ үргэлжилнэ. Хугацааны хувьд хууль санаачлагчийн зүгээс өргөн мэдүүлэхдээ ийм урт хугацаагаар тавьсан. Энийг мэдээж улс төрийн намууд, энэ парламентад суудалгүй намуудын төлөөлөл, дарга нарыг ажлын хэсэгт бас оролцуулаад энэ шаардлага тавьсан намуудын дарга нарын байр сууриудыг ингэж сонсоод хугацааг багасгах ч гэдэг юм уу ийм боломж мэдээж Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд аль аль намууд шийдээд явах бололцоотой гэж бодож байгаа. Тэрнээс биш хугацааг бас ийм хатуу тавьчихсан зүйл байхгүй. Үүнийг хөндөж орж ирж байгаа заалт учраас бүлгүүд бас улс төрийнхөө шийдвэрийг гаргаад, тэгээд хугацаан дээрээ магадгүй жил хагас ч гэдэг юм уу энэ хангалттай хугацаа гэж улс төрийн намуудтай ярилцаад үзэх юм бол бололцоотой. Тэрнээс биш энэ дээд хугацааг л ингэж тавьсан болохоос энэ хугацааг хөндөх асуудлыг Их Хурал дахь ажлын хэсэг шийдвэрлээд явах бололцоотой гэж бас үзэж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: 2 асуулт байна. Нэгдүгээрт нь Хууль зүйн яамнаас Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.8 дээр хуулийн төслүүд, Засгийн газраас өргөн барьж байгаа хуулийн төслүүдийг хуулийн энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэхийг нь шалгаж эцэслэн хянаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хурлын д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно гэсэн байгаа.

Тэгэхээр энэ заалтаар хараад үзэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10 дээр болохоор хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтыг дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй гэж заасан байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь 4.1 дээр нь болохоор энэ зарчмууд байгаа. Үндсэн хуулийн зарчмуудаас гадна нэмж 4.1.3 дээр ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, 4.1.4 дээр нь судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх гэсэн ийм шаардлагууд байгаа юм. Тэгэхээр Хууль зүйн яамнаас асуух гээд байгаа асуулт нь болохоор энэ шаардлагуудыг хангаж, энэ хуулийн төсөл маань энэ шаардлагуудыг хангаж орж ирсэн үү? Тэр юун дээр ашиг сонирхлын зөрчилтэй гээд энэ Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаатай тааруулж хийж байгаа нь жишээлбэл эрх барьж байгаа намуудад энэ чинь улс төрийн юутай, энэ асуудал нь тэр улс төрийн сонгуультай тааруулж хийж байгаа нь бас энэ ашиг сонирхлын зөрчлийн ийм асуудал байна уу,

үгүй юү? Тэгээд энэ хугацааг түрүүн бас Пүрэвдорж гишүүн хэлсэн заавал ийм Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа биш, наана нь ч юм уу, 6 сарын дараа, жилийн дараа хийх бололцоо байхад өөр ийм хувилбаруудыг судалж үзсэн үү гэдэг ийм нэг асуулт байна.

Дараачийнх нь болохоор Эх орончдын нэгдсэн намын дарга Ганбат, Монголын социал демократ намын Ерөнхий нарийн бичгийн дарга Сандуйжав гуай нараас нэг асуулт байна.

Та хэдийн сая хэвлэлийн бага хурлыг сонссон. Тэгээд тэнд болохоор ер нь энэ Улс төрийн намын тухай хууль маань жишээлбэл бид нар жижиг намууд энэ хуулийг биелүүлж чадахгүй байна, шаардлага нь өндөр байна гэдэг асуудал ярьж байсан. Зүгээр өнөөдрийн яг та хэдийн хүсэлт болохоор зөвхөн хугацааг хойшлуулаад өгөөч, тэгээд энэ хугацаан дотроо бид нар энэ шаардлагуудаа хангаж чадна гэж үзэж байгаа юу? Эсвэл энэ намын тухай хуулийн бусад өөрчлөлтүүд дээр өөр санаа, бодол байгаа юу? Энэ хугацаа нь тавиад өгчихвөл энэ шаардлагуудыг нь та хэд биелүүлж чадах уу гэдэг ийм 2 асуулт байна.

Хууль зүйн яам хэд байна наадах чинь? 6 юу? 6 номерын микрофон.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэргийн яам Жамъянхүү.

Н.Жамъянхүү: Энхтүвшин гишүүний асуултад хариульъя 3 асуудлаар байна.

Нэгдүгээрт нь хуулийн төслийг бид нар энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн заасан шаардлагыг хангасан гэж үзээд Засгийн газраас Засгийн газрын хуралдаан бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгосон. Мэдээж Хууль тогтоомжийн хуулийн 40, 41.10 дугаар зүйлийг, хэсгийг сая уншиж сонслоо. Тэгэхээр 10 дугаар зүйл бол хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хуулийн, тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтыг дагаж мөрдөх хугацаанд, дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй гэж заасан. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэж байгаа буюу Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэлэлцэж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн бид нар өөрчлөх гээд байгаа зохицуулалт бол тухайн хуулийн дагаж мөрдөх хугацааг нэгдүгээрт өөрчлөх гээгүй. Энэ зохион байгуулалтын шинжтэй бэлтгэл ажлыг хангах хугацааг хойш нь сунгахаар байгаа. Одоогийн хууль, Дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл дээр 2024 оны 7 сарын 7-ноос хойш 6 сарын хугацаа өгсөн буюу 1 сарын 7-ны өдөр буюу сар хүрэхгүй сарын хугацаанд л хугацаа өнгөрчхөөд байдаг. Тэгэхээр Сонгуулийн ерөнхий хороо болон Улсын дээд шүүхэд нэг ч намаас энэ улсын дүрмийн өөрчлөлт болон хөтөлбөрийн өөрчлөлтөө бүртгүүлсэн ийм юу байхгүй. Одоогоор энэ намууд нь өөрсдийнхөө хурал болон дээд шатны удирдах хурал болон бусад намын гишүүдийнхээ оролцоог хангана гэсэн энэ асуудлуудыг одоогоор бас хийсэн юм байхгүй хугацаа шахагдчихсан байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ цаанаа бас үр дагавартай байгаад байгаа. Өөрөөр хэлбэл, энэ хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ 30 Улсын дээд шүүхэд бүртгэл бүхий 37 нам бол хууль зөрчих ийм асуудалд орох гээд байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь Улс төрийн намын тухай хуулиар хэд хэдэн том концепцын шинжтэй өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, бүтцийн хувьд, жендерийн бас квотыг биелүүлэх асуудал байгаа. Дээр нь энэ дүрэм, журмаа өөрчлөх, дүрэм, журмаа

өөрчлөхдөө бүх гишүүдийн оролцоог бас хангахтай холбоотой ийм олон том том зохицуулалтууд орсон. Үүнийтэй уялдаад энэ өөрчлөлт намын дүрэмд болон хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ юунууд бол зайлшгүй хийгдэж, тодорхой цаг хугацааны хүрээнд намын анхан болон дунд, дээд шатын байгууллагуудаар хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай. Ингэж байж энэ дүрэм маань хүчин төгөлдөр болно. Энэний дараа Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр байгаа.

Хоёрдугаарт нь мөн адилхан Хууль тогтоомжийн хуульд заасан тэр судалгаа энэ тэрийг бүгдийг нь хийсэн. Судалгаануудаас Хууль тогтоомжийн хуульд заасан 3 төрлийн судалгаа хийгдсэн байдаг. Энэ дээр тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын судалгаанууд хийгдсэн. Мөн энэ улс төрийн намуудаас болон Засгийн газрын гишүүдээс саналыг авч цахимаар саналыг бас мөн авсан байгаад байгаа. Иймэрхүү шаардлагуудыг энэ юу бол хангаж орж ирж байгаа юм.

Хугацааны хувьд 27 оны 8 сарын 1 гэж орж ирж байгаа. Энэ нь бол хамгийн цаад хугацаа. Тэгэхээр намууд 37 намууд бас ямар ч нам одоо дараагийн 6 сарын хугацаанд юм уу, жилийн хугацаанд энэ өөрчлөлтийг хийгээд, хуралдуулаад удирдах байгууллагаараа батлуулаад Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр хүргүүлэх боломжтой. Заавал 27 оны 8 сарын 1-ийг хүргэх шаардлага байхгүй.

27 оны 8 сарын 1 гэдэг бол хамгийн эцсийн хугацааг тавьж өгсөн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эх орончдын намын дарга Г.Ганбат 4 дүгээр микрофон.

Г.Ганбат: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид нэг зүйлийг л ойлгомоор байгаа юм. Монгол Улсад үнэхээр энэ олон намын тогтолцоо бэхжчихсэн юм уу, хөгжчихсэн юм уу? Үгүй энд чинь нэг л өнөөдөр би Улсын Их Хурлын гишүүдтэй ингээд уулзаад явж байхад энэ асуултыг л асуумаар байгаа юм. Үнэн хэрэгтээ Монголд чинь энэ гаж зүйл л яваад байгаа шүү дээ. Парламентад байдаг хэдэн нам нь ингээд болоод байдаг, парламентын гадна байгаа намууд нь ингээд хаягдаад ерөөсөө өлгийндөө л байхгүй болчхож байгаа шүү дээ. Тэгэхээр энийг яагаад засахгүйгээр энийг урагш нь шинэчлэл хийхгүйгээр, маш өргөн хүрээнд харахгүйгээр яаж ингэж цаашаа явах гээд байгаа юм бэ. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийг бид нар намууд маш нухацтай хүлээж авсан. Хүлээлт үүсэж байсан.

Гэтэл парламентын түвшинд байгаа хэдэн намын түвшинд л хийгдсэн шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ гор нь өнөөдөр ингээд л гарч байгаа байхгүй юу. Үнэн хэрэгтээ парламентад байсан тэр 3 нам гэнэ үү, 5 нам гэнэ үү тэр хүрээндээ л харсан. Яагаад гэвэл тэнд нь санхүүжилт байна, эрх.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Байж байгаарай 4 номерын микрофоныг дахиад сунгая.

Г.Ганбат: Тэгээд би Улсын Их Хурлын гишүүддээ ингэж л хэлмээр байгаа юм. Ер нь тэр явцуу утгаар нь парламентад байгаа намуудын хүрээнд биш энэ 37 намуудын хүрээнд хараач, өргөн агуулгаар нь та нар тэр Үндсэн хуулийн олон ургалч үзэл санаа, олон намын тогтолцоог Монгол Улсад бэхжүүлэх талаар харж үзээч. Үндсэн хуулийн тэр өөрчлөлтийг 2019 онд хийхдээ ер нь энэ улс төрийн намын шинэчлэлийн асуудал, төлөвшлийн асуудал бол нэг удаагийн өргөс авч байгаа юм шиг ингээд явчих зүйл биш байна энэ. Яагаад гэвэл энэ чинь маш их

хоцрогдсон төлөвшөөгүй учраас удаан хугацааны тийм бэлтгэл ажлууд шаардах асуудал байна. Тийм учраас тэр улс төрийн намын шилжилтүүдийг тэр 2028 оны 1 сарын 1 хүртэл гээд бүүр Үндсэн хуулийн өөрчлөлт хийхдээ хүртэл юу тавьж байсан шүү дээ. Энэ өөрөө бодлого биш юм уу?

Тэгэхээр энийг өнөөдөр зүгээр биднийг харж байгаа юм шиг мөртөө энэ парламентад байгаа хэдэн намуудын хэмжээнд хараад тэр үндсэн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Монголын Социал демократ намын төлөөлөл Ж.Сундуйжав 5 номерын микрофон. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Ж.Сандуйжав: Төрийн байгуулалтын байнгын хорооны нийт гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Түрүүчийн үг хэлсэн хүмүүсийн санааг би давтахгүй 2 зүйл дээр мэдээлэл өгөхийг хүсэж байна.

Нэгдүгээр зүйл нь улс төрийн намын намынх нь өөрийн мөрийн хөтөлбөр гэж маш чухал баримт бичгийн асуудал хуульд тавигдсан байгаа. Тэгэхээр мөрийн хөтөлбөрийг манай намынхны ойлгож байгаагаар тухайн намын үзэл баримтлал барууны нам уу, зүүний нам уу, төвийн нам уу гэдэг асуудал маш чухал. Өөрөөр хэлбэл, энэ бол улс төрийн шинжлэх ухааны асуудал юм.

Тийм учраас энийг бид Үндсэн хуультайгаа нийцүүлж намууд өөрсдийнхөө үзэл баримтлалыг орчин үеийн чиг хандлага нь ямар байх вэ, уламжлалт.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 5 дугаар микрофоныг дахиад 1 минут сунгая.

Ж.Сандуйжав: Европын улсад үүсэж байсан тэр уламжлалт тогтолцоотой яаж уялдах вэ гэдэг талаас нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж харж, энэ үзэл баримтлалаа тодорхой болгож намынхаа мөрийн хөтөлбөрийг хийх учраас нэлээн цаг хугацаа шаардлагатай байгаа юм.

Хоёр дахь нь манай Монголын социал демократ намын гишүүд, албан ёсны бүртгэлтэй гишүүд үндсэндээ 90 гаран хувь нь 1990 оны анх нам байгуулж байсан үеийн гишүүд байдаг. Өөрөөр хэлэх юм бол, дандаа миний үеийн хөгшчүүл байгаа. Эднээс маш олон гишүүд намынхаа гишүүнчлэлээс больж, дэмжигчийн байр суурьтай байя гэсэн саналыг байнга дэвшүүлдэг.

Тийм учраас намын гишүүдийн шинэчилсэн бүртгэлийг гаргахад нэлээн тодорхой цаг хугацаа хэрэгтэй байгаа гэдгийг та бүхэн ойлгоорой. Бусад хүмүүсийнхээ ярьсан асуудлыг бүгдийг дэмжиж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Хууль зүйн яамнаас тэгвэл та хэдийн судалгаагаар 6 юм уу жилийн хугацаанд бас боломжтой гэсэн ийм судалгаа гаргасан юм байна даа гэж ойлгож байна зөв үү 6 сар? 6 сар юм уу 1 жилийн хугацаанд улс төрийн намууд энэ шинэ хуульдаа нийцүүлээд дүрмээ, хөтөлбөрөө гаргах бололцоотой юм байна гэж ойлголоо. Зөв үү гэдэг тэрийг баталгаажуулмаар байна.

Түрүүн бас Ганбат дарга, Сандуйжав гуай хоёроос асуусан асуулт дээр саяын энэ хуульд нийцүүлээд дүрмээ өөрчлөхөд та хэд боломжтой юм уу гэдэг тийм асуулт асуусан арай жоохон өөр хариулт хариулчих шиг боллоо.

Ж.Бат-Эрдэнэ: 6 номер.

Н.Жамъянхүү: Хугацааны хувьд яг судалгаагаар тодорхой яг тэд эд байна гэсэн нарийвчилсан өөрөөр хэлбэл, 1 жилийн дотор гэсэн хугацаа байхгүй. Хамгийн боломжит хугацаа нь 32 сар буюу 2 жил 6 сарын хугацаагаар тогтоосон байгаа.

Гэхдээ энэ маань бас хэлэлцэх эсэх нь шийдэгдэх юм бол эргээд ажлын хэсгийн хүрээнд бас нааш нь богино болох ийм боломжтой байх.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Хуультай холбоотой болон бусад ганц, хоёр асуулт байна. Хууль тогтоомжийн тухай хуулиараа 38.1-д жишээлбэл олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой, тэгээд түүнийхээ материалыг хавсаргана гэж байгаа. 38.7-д болохоор олон нийтийн хэлэлцүүлэг хийгээд, саналыг товьёг болгож бас хавсаргана, цахим орчинд байршуулна гэсэн байгаа. Тэгэхээр энэ хууль бол яг хууль зүйн дагуугаа бүрдүүлбэр дутуу юм биш үү? Тэгэхээр ийм бүрдүүлбэр дутуу хуулийн төслийг Улсын Их Хурал маань хүлээн авч ингэж хэлэлцүүлэх гэж байгаа нь зөв юм уу гэдэг нэг асуулт.

Хоёрдугаарт, улс төрийн намууд маань миний сонссоноор багагүй тооны улс төрийн намууд дүрмээ өөрчлөөд өгчихсөн гэж байгаа. Тэгэхээр хэдэн нам яг өнөөдөр Улсын дээд шүүхэд дүрэмдээ өөрчлөлт оруулаад өгчихсөн байгаа вэ? Энэ тоог.

Гуравдугаарт, уг нь манай энэ том том намууд л байна л даа, Социал демократ нам маань байна, Бүгд найрамдах нам маань байна, одоо бараг л 30 гаруй жилийн түүхтэй энэ том намууд маань тэр 7, жижиг, том гэх нь хаашаа юм 7 өөр нам жишээлбэл дүрэмдээ өөрчлөлт оруулаад ном ёсоор нь Улсын Дээд шүүхэд өгчихсөн байхад манай бараг том гэгдэхүйц энэ Жаргалсайхан ахын маань нам Социал демократ нам маань яагаад амжихгүй, яагаад боломжгүй ингээд байгаад байгаа юм бэ? Уг нь та хэд чинь хамгийн илүү чадалтай, хүчтэй олон жилийн түүхтэй ийм намууд биз дээ гэж ингэж бас асуулт асуумаар байна.

Тэгээд энийг уг нь манай Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн 1.1.9-д байгаа л даа. Улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлнэ, ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлнэ, санхүүжилтийг шилэн болгоно гээд. Тэгэхээр энэ Ерөнхийлөгч энэ мөрийн хөтөлбөртөө үндэслэж өөрөө энэ хуулийн төслийг өргөн барьж батлуулсан байгаа. Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийн өргөн батлуулсан хуулийг үтэр түргэн хэрэгжүүлээд цаашаа явах ёстой атал ингээд хэрэгжилтийг нь ингээд хойшлуулаад байж болж байгаа юм уу? Дахиад энэ чинь хориг ирэх юм биш биз дээ гэдэг ийм асуулт байна.

Дахиад энэ зөвхөн 2 дугаар заалтыг нь хойшлуулж байгаа гээд байгаа юм. Гэтэл энэ чинь бусад заалтуудтайгаа уялдаатай биш юм уу? Тэгэхээр санхүүжилтээ авч чадахгүйд хүрнэ гэж би бол харж байгаа. Энэ чинь маш нарийн уялдаа байгаа. Дүрэмдээ өөрчлөлт оруулж байж тэр дүрмийнхээ дагуу тайлан юмаа тавьж байж сая санхүүжилтээ авна. Тэгэхээр манай энэ улс төрийн намууд маань үтэр түргэн тэр дүрэмдээ өөрчлөлт оруулаад, он гараад тэр санхүүжилтээ аваад эхлэх ёстой юм биш үү үг нь бол? Тэгээд тэр санхүү мөнгөөрөө энэ намаа улам бэхжүүлэх, сайн болгох, энэ чиглэл рүү явах ёстой юм биш үү гэдэг ийм зүйл байна. Ер нь бусад намууд ч гэсэн маш олон зүйлийг амласан. Ер нь бүх энэ муу муухай бузар булайн эх үүсвэр бол бараг ний нуугүй хэлэхэд манай энэ улс төрийн намууд бид өөрснөө. Энд бол авлига цэцэглэж байдаг. Эндээс ерөөсөө бүх муу муухай юм гарч байдаг. Тэгэхээр энэ улс төрийн намуудыг цэвэршүүлбэ, сайжруулъя гэдэг нь хамгийн бид нарын хийх ёстой чухал зүйл байгаа юм. Тэгээд энэ улс төрийн намуудад маань ч гэсэн амласан.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Учрал гишүүн, Учрал сайд хариулах уу?

Н.Учрал: Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-тай холбоотой асуудлуудыг бас гишүүд хөндөөд байгаа. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ хууль тогтоомжийн бүрдүүлбэрийг хангаад, тандан судалгаагаа хийгээд зөвхөн дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйлийг л тодорхой хугацаагаар хойшлуулъя гэдэг ийм хуулийн төслийг санаачилж Засгийн газар хэлэлцэж, Засгийн газраас Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тэгэхээр процедурын хувьд ямар нэгэн хууль зөрчиж байгаа зүйл байхгүй гэж хэлэх ёстой байх. Тэгээд үүн дээр бас Хууль зүй, дотоод хэргийн яам бас нэмэлт тайлбар хийх нь зөв.

Дагаж мөрдөх журмын хууль дээр энэ 5 зүйл байгаагийн тэр 2 дугаар зүйл гээд байгаа нь дүрэмтэй холбоотой, шинээр бүртгүүлэхтэй холбоотой л харилцаа. Тэрнээс биш энэ 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш энэ улс төрийн намын хуулийг 6 сарын дотор энэ хуультайгаа дотоод үйл ажиллагаагаа зохицуулах ийм 6 сарын хугацаа өгсөн. Энэ цаг хугацаанд мэдээж улс төрийн намууд дотооддоо хурал зөвлөгөөнөө хийгээд, дүрмийн өөрчлөлтөө хэлэлцүүлээд энэ тэр явж байгаа бас намууд байгаа л гэдэг мэдээллийг өгч байгаа. Одоо бол 1 дүгээр сарын 1-ээс эхлээд шууд хаагдаад Дээд шүүхэд 30 хоногийн дотор бүртгэлээ явуулна.

Ингээд Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс ч гэсэн ямар мэдээлэл өгсөн бэ гэхээр Улсын дээд шүүх тайлбар ирүүлсэн. Улсын дээд шүүх тайлбар ирүүлэхдээ Улс төрийн намын хуульд хэрвээ үйл ажиллагаагаа нийцүүлээгүй байгаа тохиолдолд дээд шүүх бүртгэхгүй буюу тухайн улс төрийн нам татан буугдсанд ингээд тооцох ийм эрх зүйн үр дагавар үүсчхээд байгаа юм. Тэрнээс биш Улс төрийн намын хуулийн батлагдсан тэр концепц бол одоо хэрэгжээд л явна гэсэн үг. Зөвхөн тэр, зөвхөн дүрмээ өөрчлөөд шинээр бүртгүүлэхтэй холбоотой материалуудыг бүрдүүлж Дээд шүүхэд хүргүүлэх асуудал нь байгаа болохоос биш, түрүүн хэлсэн тэр санхүүжилт ил болгох, нээлттэй болгох, тэгээд л жишээ нь анх удаа дэмжигч гишүүн гэдэг статус ороод ирлээ гэхэд дэмжигч гишүүдийгээ бүртгэлжүүлэх, түүнийхээ материалыг нэгтгээд хүргүүлэх гээд ингээд л асуудлууд хүртэл цаг хугацааны хувьд ямар ч бололцоо байхгүй гээд өөрсдөө ийм парламентад суудалгүй намууд хүсэлтээ ирүүлээд байгаа юм л даа.

Тийм учраас энэ хүсэлтүүдэд нь үндэслээд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ хуулийн төслийг боловсруулсан. Тийм ч учраас энэ хүсэлт ирүүлсэн намууд өөрсдөө ажлын хэсэгт ороод ингээд явж байгаа юм. Тэрнээс биш 37 улс

төрийн намууд дотооддоо ямар үйл ажиллагаа зохион байгуулж байгаа юм, яаж бэлтгэл ажил хангуулсан юм, дүрмийн өөрчлөлтөө хийсэн юм уу, үгүй юм уу гэдгийг дотоод үйл ажиллагаа руу орох тийм бололцоо хэнд ч байхгүй шүү дээ. Гол нь дараа нь мэдээж Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсаны дараа 37 улс төрийн намыг нээлттэйгээр ажлын хэсэгт уриад тэр 2 жил 6 сар тэр 32 сарын хугацааг багасгах уу, яах вэ гэдгийг нээлттэйгээр яриад хэлэлцээд явах нь зөв гэдэг ийм л шалтгаан хэлж байгаа. Мэдээж парламент суудалтай намуудын хувьд хурал, зөвлөгөөнөө хийгээд явахад бас төдийлөн бэрхшээл бас үүсэхгүй байх. Парламент суудалгүй намуудын хувьд нээрээ л хөрөнгө санхүү, дээрээс нь цаг хугацааны хувьд, мөн 21 аймгаар явж гишүүдээ шинээр бүртгэлжүүлэх, одоо ингэнэ гэж байна шүү дээ намын анхан шатны байгууллага бүр 40 хувь нь хүйсийн эрхийг хангах ёстой гээд жендерийг дурдчихаад байгаа байхгүй юу хуулиар. Тэгэхээр 40 хувьд тутамд эмэгтэй хүн эсвэл аль нэг хүйсийн төлөөлөл байна гэдэг маш хүндээр тусаж байна.

Тийм учраас гишүүнчлэлээ сэргээх, шинээ гишүүнчлэлтэй болгох гээд ийм асуудлуудыг зайлшгүй бас тодорхой хугацаа өгөөч л гэж энэ улс төрийн намууд хүсээд байна гэж би ойлгож байгаа. Ингээд Хууль зүйн яамнаас нэмээд, тэгээд ажлын хэсгээс нэмээд хариулчих байх.

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микро микрофон.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль тогтоомжийн хуулийн 38.3 3-д энэ цахимаар хэлэлцүүлэг цахим хэлбэрээр хэлэлцүүлэг хийхээр бас хэлбэрийн хувьд заагаад өгчихсөн. Энэний хүрээнд хуулийн төсөл болон холбогдох судалгаа, үзэл баримтлал, танилцуулгыг цахимд байршуулж саналуудыг авсан байгаа. Хэрэг эрхлэх газарт хүргүүлсний дараагаар бас 20 орчим саналууд энэ цахимаар ирсэн байдаг саналын хувьд.

Хоёрдугаарт, санхүүжилтийн байдал, санхүүжилт эд нар зогсох гээд байна гэсэн ийм бас гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны өгсөн мэдээллээр бол одоо яг энэ Улс төрийн намын тухай хуулийн дагуу нийтдээ 7 нам төрөөс тодорхой хэмжээний санхүүжилт авахаар байна лээ, мэдээ байна лээ. Энэ намууд нь бол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэдэн номер? 6 номер гүйцээж хариулъя.

Н.Жамъянхүү: Эдгээр 7 намууд нь бас яг тодорхой өөрсдийнхөө санхүүгийн холбогдох ажилтнуудыг томилоод энэ бэлтгэл ажлаа Сонгуулийн ерөнхий хороотой хамтраад хийгээд явж байгаа юм билээ. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн доголдол үүсэхгүй гэсэн ийм тайлбарыг Сонгуулийн ерөнхий хорооноос бас өмнөх хурлууд дээр өгч байсан. Хэрэвзээ энэ хугацаа бид нарын 6 сарын хугацаа энэ 1 сард дууссан тохиолдолд ялангуяа энэ Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын яг энэ бүртгэлтэй холбоотой яах вэ гэдэг зохицуулалт нь Улс төрийн намын тухай хууль дээрээ байхгүй. Тэгэхээр энэ дээр яах аргагүй ийм хийдэл цонх үүсээд цаашдаа энэ намуудыг нөхөж бүртгэх юм уу, бүртгэхгүй юм уу, намууд нь цаашаа үйл ажиллагааг үргэлжлүүлэх юм уу, үгүй юм уу гэсэн ийм хүндрэлтэй яг хууль хэрэгжүүлэхэд болон энэ намуудад бас ийм хүндрэлтэй асуудал яг хууль зүйн талаасаа үүсэх гээд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Тодруулж асууя. Ер нь энд надад бас нэрс нь байна л даа. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам гээд сонсоо ч үгүй шахам нам сая 20-нд өгсөн байна, Монголын үндэсний ардчилсан нам 25-нд буюу уржигдар өгсөн байна, Монголын ногоон нам өгсөн байна гээд ингээд Ард түмний олонхын засаглал нам гээд энэ 7 нам ингээд яаж ийж байгаад өгчихсөн байна л даа. Тэгэхээр би энэ Жаргалсайхан ах энэ тэрээс л асуумаар байгаа юм. Энэ хамгийн том гэгдэх намууд шахам юм байж яагаад өгөөгүй юм бол?

Хоёрдугаарт, энэ дүрэм, хууль хоёр чинь зөрчилдөх юм биш үү? Одоо ингээд эхэлчихсэн байгаа шүү дээ. Жишээлбэл, дэмжигч гишүүн гэж дүрэмд нь байхгүй намууд алийг нь баримталж явах вэ 1 сарын 1-ээс? Энэ чинь ярих юм байхгүй зөрчил үүснэ шүү дээ. Тэгээд миний тэр бас холбогдох төрийн бус байгууллагуудтай уулзаж байхад энэ санхүүжилт тийм амар биш. Яг тэр дүрэм дээр суурилж тайлан гаргаж өгч, тэр тайлан дээр үндэслэж мөнгө төгрөгөө авна гээд бас нарийн юм байгаа юм байна лээ. Тэгэхээр Сонгуулийн ерөнхий хороотой яриад авчихдаг юм байгаа эсэхийг би бас мэдэхгүй байна тэр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Бүгд найрамдах намын дарга Жаргалсайхан 9 номерын микрофон.

Б.Жаргалсайхан: Тэгэхээр бид нар шинэ эрин зуунд, хиймэл оюун ухааны эрин зуунд амьдарч байна. Тэгэхээр нам байгуулна гэдэг чинь албан тушаал авах гэж нам байгуулдаггүй юм. Нам бодлого гаргаж ирдэг юм. Нийгмийг яаж төлөвшүүлэх вэ, ямар эдийн засгийн тогтолцоотой цаашаа явах вэ энэ бодлогуудыг гаргаж ирдэг байхгүй юу. Бүгд найрамдах намын хувьд тэрний төлөө явж ирсэн, мөн нэлээн ч олон бодлогыг оруулж өгсөн энэ улсад ажил болгосон.

Жишээлбэл, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хууль гаргаж байсан, гаргаж санаачилж өгсөн. Тэрүүгээр чинь олон жижиг, дунд үйлдвэрүүд санхүүжилт аваад ингээд ажлаа хийгээд хүнээ тэжээгээд явж байна. Ашигт малтмалын хууль гаргаж өгсөн. 34, 51 гээд. Яагаад 34 байдаг юм бэ, яагаад 40 байдаггүй юм бэ л гээд асуугаад байна. Аж ахуйн нэгжүүдийн хуулийг унших хэрэгтэй байхгүй юу. Яагаад 34.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 9 номерын микрофон.

Б.Жаргалсайхан: Тэгэхээр коммунизмын үед нам байгуулах нэг асуудал. Тэнд бол үзэл суртал, тэгээд виртуал удирдлагатай, бүгдээрээ даргын үгийг дагаж явдаг. Одоо бид нар зах зээл, ардчилал, хүний эрх гээд явж байна. Энд нийцүүлж бид энэ улс төрийн ажлыг явуулдаг. Тийм ээ сонгуулиар луйвар булхай хийж байгаад мөнгө тараагаад Их Хуралд ороод суучхаж болно. Бид тэгэхдээ хэзээ ч тэгж байгаагүй, тэгчих үү цаашдаа. Бид шударга, зарчимтай, хариуцлагатай сонгуульд хандаж ирдэг. Тодорхой оноо авсан нь мөнгө авах юм билээ Баярмаа гишүүнээ тэрнээс хүн болгонд ч бас тэр намуудад мөнгө тараах гээд байгаа юм байхгүй юм байна лээ.

Дараачийн асуудал ер нь Их Хурлын гишүүдээ намуудын нэр хүнд муу байна, улс төрчдийг муу байна гээд байдаг та нараас болж байгаа юм. Та нар камер хараад зүгээр нийгэм, улс орныхоо асуудлыг хэлэлцэхийн оронд бие биеийгээ харлуулж.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлаар миний мэдэгдэх л лав анх удаагаа ийм хууль дээдлэх ёсыг зөрчсөн ийм зарчимгүй хуулийн төсөл орж ирж байна л даа. Яагаад зарчимгүй гэж байгаа юм гэж. 23 оны 7 сард энэ хуулийг маш сайхан тал талаас, маш сайхан нийгмийн болохгүй бүтэхгүй үндэс улс төрийн нам, улс төрийн намыг шилэн болгоё, улс төрийн намыг бодлогын нам болгоё, улс төрийн намыг бүтэц, сүлжээнээс нь холдуулъя гэдэг олон сайхан зүйлийг ярьж энэ хуулийн төсөл маш өндөр хувийн дэмжлэгтэйгээр батлагдаж байсан.

Яг хэрэгжих болоод ирсэн чинь хууль хэрэгжүүлмээргүй байна улс төрийн намууд. Ер нь засагт олон нам хамтарчихсан юм чинь ер хуулийг өөрчлөөд хуулийн дээр гараад суучихъя гэдэг л ийм л үг, зарчим л орж ирж байна. Энд тайлбар хийж байгаа нь тэр 37 намаас бас хууль хэрэгжүүлмээргүй байна гэсэн цөөнийг нь энд авчраад ингээд ялгаад суулгачихсан. Тэнд нөгөө талын тэр хуулиа хэрэгжүүлээд өгч байгаа тэр 10-аад намын яагаад энд оруулж энэ ажлын хэсэгт нь оруулж ирдэггүй юм? Тэгээд энэ асуудлыг Ардчилсан намын бүлгийн зүгээс бас дэмжээгүй.

Яагаад гэвэл энэ хуулийн чинь үзэл санаа чинь өөрөө энэ хуулийг хэрэгжүүлэхгүй тэгэхдээ татвар төлөгчдийн мөнгөнөөс бид нар мөнгийг нь авна. Энэ хуулиар өгөх гэж байгаа мөнгийг нь авна, хуулийг чинь хэрэгжүүлэхгүй гэдэг ийм л үзэл санаа энэ хуульд чинь ингээд нэвт шингэчихсэн ийм л нөхцөл байдалтай байна. Тэгээд энэ дээр бас үгүй яах вэ ганц, хоёр асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ яагаад энэ цаг хугацааны ийм шахаанд энэ хуулийг ингэж оруулж ирж байгаа юм бэ? Шахаа гэдэг нь одоо ирэх 7 хоногоос 12 сар гарлаа. Энэ хууль чинь хэрэгжихэд ганцхан сарын хугацаа үлдчихсэн байна. Тэгэхэд анхны хэлэлцүүлэг нь хийгдээгүй, одоо ажлын хэсэг гараад, дахиад энд дунд энэ эцсийн хэлэлцүүлэг хийгдлээ, Ерөнхийлөгчийн хориг гээд ингээд цаашаа цаашаа явахад энэ чинь өөрөө яг ямар нөхцөл байдлыг нь дагуулж болох юм энэ цаг хугацаа чинь өөрөө?

Хоёрдугаарт нь тэр Хууль тогтоомжийн хуулийн 41.10 гэдэг дээр бас тодорхой тайлбар хэрэгтэй юм байна лээ. Энэ хууль чинь хэрэгжээд эхэлчихсэн хууль шүү дээ. Бүтнээрээ 24 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж байгаа, зарим заалт нь 7 сарын 1-ээс хэрэгжиж байгаа. Хэрэгжээд эхэлчихсэн. Тэр Хууль тогтоомжийн тухай хууль дээр чинь аль мөрдөгдөж байгаа хуулийг нь хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй гэхсэн. Өөрчлөлт гэдэг нь урагшлуулж, хойшлуулж ямарваа өөрчлөлт оруулахгүй гэхсэн байна л даа. Тов тодорхой заалт байна.

Тэгэхээр яагаад ийм цаг хугацаа давчуу шахчихсан, нөгөө талаасаа ийм хуулийн зөрчилтэй ийм хууль дээдлэх зарчим, олон зүйлээ, хуулийг ер нь товчхондоо хуулийг хэрэгжүүлмээргүй байна л гэсэн хууль шүү дээ. Хуулийг хэрэгжүүлэхгүй. Жирийн иргэд Монгол Улсын гарсан хуулийг би хэрэгжүүлмээргүй байна, тэр Зөрчлийн хуулийг хэрэгжүүлмээргүй байна гэвэл яадаг юм болдог юм уу, тэр саналуудаа гаргаад явбал ингээд хэлэлцээд явж болдог юм уу? Зүгээр намууд болохоор нийлж байгаад ингээд дураараа хуулиар тавьсан цаг хугацаа, бүх зүйлсийг ингээд дураараа өөрчлөөд яваад байж болдог юм уу?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт Хууль зүйн яам 6 номерын микрофон.

Н.Жамъянхүү: Хууль зүйн яам Жамъянхүү.

Хуульд, 1 дүгээр асуултад хариульъя. Хууль тогтоомжийн хуулийн 40.10 дээр би уншаад өгье хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй гэж заасан. Өөрөөр хэлбэл, тухайн хууль 2024 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

Харин өнөөдрийн боловсруулж оруулж ирсэн дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл дээр байгаа хугацаа бол бэлтгэл ажлыг явуулах, бэлтгэл ажлыг хангахтай холбоотой хугацаа. Харин бид нар энэ хуулийг Улс төрийн намын тухай хуулийг эсвэл Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын хууль дээрх дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулаагүй байгаа.

Мөн одоогоор улс төрийн намуудаас бас тодорхой хэмжээний саналууд ирсэн. Одоогоор 7, 8 намын санал ирүүлчхээд байгаа. Энэ хооронд энэ яах аргагүй Дагаж мөрдөх журмын хууль дээр заасан бэлтгэл ажил хангах энэ хугацаа маань өөрөө 1 сарын 7-ны өдөр дуусаж байгаа. Энэ хооронд энэ Улсын дээд шүүх дээр бас энэ улс төрийн намууд дүрэм болон хөтөлбөрөө, мөрийн хөтөлбөрөө өөрчлөх, өөрчилсөн талаар ямар нэгэн тийм хандсан хандалт байхгүй байгаад байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ 1 сарын 7-ны өдрөөс эхлээд энэ хууль дээр улс төрийн намуудын бүртгэл байх, нэг ёсондоо хар үгээр хэлэхэд бүртгэл дээр асуудал үүсээд энд хийдэл үүсээд ирэх ийм байгаа. Цаашдаа энэ намууд маань яаж бүртгүүлэх вэ, шинээр бүртгүүлэх юм уу, сунгах юм уу гэдэг нь яг Улс төрийн намын тухай хууль дээр тодорхой зохицуулалтууд бас байхгүй байгаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Энхбаяр, Энхтүвшин, Баярмаа гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Улс төрийн намын шинэчлэл, улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг бид сүүлийн 20 жил парламентад болон парламентын улс төрийн намуудын хүрээнд их идэвхтэй ярьж энэ реформыг хийсэн. Өнгөрсөн парламентын үед хийгдсэн 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг амилуулах хүрээнд гол хийгдсэн томоохон шинэтгэлийн нэг нь энэ Улс төрийн намын хууль байгаа юм.

Энэ хуулийг боловсруулах хүрээнд парламент суудалтай болон суудалгүй намуудын хүрээнд, мөн ажлын хэсгийн хүрээнд олон улсын сайн туршлага, жишгүүдийг нэлээн нэвтрүүлж манай Ц.Мөнхцэцэг гишүүн ажлын хэсгийг нь ахалж байсан. Нэлээн ардчилсан улс орнуудын парламентын загваруудаас авсан сайн хууль шинэтгэл болсон гэж ингэж баталсан юм бас. Энийг энэ зөвхөн боловсруулалтын хүрээнд энэ хуулийн төсөл дээр 2 жил лав суусан юм. Тэгээд би ч гэсэн бас ажлын хэсэгт нь бас бас анхны ноорог гарахад нь 21 онд лав сууж байсан. Энэ нэлээн тийм дэвшилтэт, прогрессив, урагшаа харсан ийм шинэтгэл болсон юм.

Тэгээд энэ шинэтгэлээ бид хэрэгжүүлэх дээр парламентын намууд, парламент суудалтай суудалтай, суудалгүй намууд зарчмын хувьд хатуу зогсох

ёстой шүү. Улс төрийн нюанс байна, ойлгож байна. Яагаад хойшлуулах гээд байгааг нь ч ойлгож байгаа. Нуугаад энэний урд нь манай Буян Жагаа ах гарч ирээд л явж л байна л даа. Миний мэдэхийн хүүхэд байхын л, намайг хүүхэд байхад л та намын дарга байсан шүү дээ.

Тэгэхдээ би таныг намын хурлаа хийж байсан гэж танаас өөр Бүгд найрамдах намын гишүүн гэж би лав олж харж байсан зүйл байхгүй. Намын хурал нь гэж хаана болж байсан юм? Насаар нь томилчихсон юм уу айн? Насаараа намын дарга болчихсон хэдэн хүн байгаад байгаа шүү дээ. Тэгээд биеэ үнэлдэг. Насны эцэст бас энэ сайхан капиталыг биеэ үнэлэгч нэртэй дуусгах харамсалтай л байна. Тэгээд том намуудын юу ч болоод байгаа юм, нэг бол хуулийн юманд бууны нохой гэж их муухай үг шүү дээ энэ чинь. Муу, том хүмүүсийн гар, хөл болж, муу юманд ашиглагдаж тэгээд муу үйлийг гүйцэлдүүлж, тэгээд насны эцэст бас жоохон сайн сайхан юмтай болсон юм чинь үр хүүхдэдээ бас жоохон өөр ертөнцөд очсон ч гэсэн бас хэлэх нүүртэй баймаар байна шүү дээ.

Тэгээд л 30 жил биеэ үнэлнэ гэж ямар юм байсан юм бэ энэ чинь айн? Нэр ч байхгүй, нүүр ч байхгүй, намтар ч байхгүй. Тэгээд л нэг мөнгөөр авдаг, мөнгөө дандаа энд тэндхийн төрийн зээлээр, хөнгөлөлттэй, хугацаагүй, ийм юмаар тохирдог, өөрөөс нь өөр хүмүүс байдаг ч юм уу, үгүй ч мэд юм уу мэдэгдэхгүй, тэгээд сонгуульд орохоороо мөнгөөр, нэр хүндээр, ард түмний итгэл энэ саналыг худалддаг ийм намуудыг цэгцлэх ёстой. Тэгэхээр намын хурлаа хийе гэдгийг бол Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам эд нар хийх дээр би ямар ч асуудал байхгүй байгаа л гэж бодож байна. Энд айж зугтаад байгаа, хурлаа хийхгүй, цаг хугацааны хүчин зүйл байхгүй байгаа л гэж бодож байна.

Тийм учраас энэ аль аль талдаа бас дүгнэлт хийх хэрэгтэй. Сонгогчид маань хэрсүү болсон, сонгогчид маань хэрсүү болсон шүү. Тийм учраас бид нар урагшаа хийсэн ийм том шинэтгэлийг нэг ийм жижиг сонирхлоор хойшлуулдгаа бас боливол яасан юм бэ? Их Хурал маань дүгнэлт хийгээсэй л гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалсайхан дарга аядаарай, дуугүй аядаарай одоо боллоо, хэлэх үгээ хэлсэн өөрөө.

Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Би санал хэлэх гэсэн юм.

Ер нь Монгол Улсын хөгжилд улс төрийн намууд чухал үүрэгтэй, улс төрийн намуудын төлөвшил тэгээд энэ чиглэлд хийсэн энэ Улс төрийн намын тухай хууль бас нэлээн ярилцаж байгаад энэ өөрчлөлтөө хийсэн юм байна. Тэгээд энэ дэвшилттэй, илүү сайжруулах гэж байгаа энэ зүйлээ ийм тавиу хугацаа тавьж аажуу алс хэрэгжүүлэх биш аль болохоор боломжит хамгийн ойрхон хугацаага тавиад, аль болох эртхэн энэ хуулиа хэрэгжүүлэх нь зөв юм уу гэсэн ийм санал байгаа.

Тэгэхээр 2000, Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа хүртэл ингэж хойшлуулах биш, аль болохоор боломжит наад хугацаа руугаа хагас жил байна уу, жилийн хугацаагаар ч юм уу ийм хугацаагаар наашаа татвал яасан юм бэ гэсэн ийм санал байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн үгээ хэлье.

Ж.Баярмаа: Нам энэ татан буугдана гэж л яриад байх шиг байна л даа. Тэгээд би энэ хуулийг уншихаар дүрэмдээ өөрчлөлт оруулаагүйгээс болж татан буугдах, тарах тухай ийм заалт олохгүй байна. Тэгэхээр ийм юм байхгүй байх. Тэгэхээр энэ дээр ингэж одоо худлаа ч юм уу ярих шаардлагагүй байх.

Тэгээд сая өмнөх гишүүдтэй яг санал нэг байна л даа. Улс төрийн нам бол хамгийн чухал, улс төрийн намын үйл ажиллагаа хамгийн цэвэр байх ёстой, санхүүжилт нь ил байх ёстой, гишүүд нь ёс зүйтэй байх ёстой гээд л ёстой амаа цангатлаа л бид нар ярьдаг шүү дээ. Тэгээд энэ бүхэнд чинь маш том түлхэц, нөлөө үзүүлэхүйц энэ хуулийн шинэчлэлийг хойшлуулах гээд байгааг ерөөсөө дэмжмээргүй байна. Бүх улс төрийн намууд маань бас энэ ялангуяа Ардын нам эндээ маш олон заалт оруулсан байгаа шүү дээ. Улс төрийн намуудыг хэн нэгэн болон хэсэг бүлэг явцуу ашиг сонирхолд үйлчлүүлэхгүй болгоно энэ тэр гээд энэ танай намын энэ мөрийн хөтөлбөр дотор байж байгаа шүү дээ. 20 оныход ч тэр, 24 оныход ч тэр.

Тэгэхээр энэ бүх амласан энэ амлалтынхаа дагуу аль болох л энэ Улс төрийн намын тухай хуулийг хурдан хэрэгжүүлж, энэ улс төрийн намаа зөв зохистой болгох, цэвэр болгох, энэ тал руугаа хурдан орох хэрэгтэй байх. Зүгээр ар дээр нь ямар шалтгаан, ямар улс төрийн юм яваад байгааг мэдэхгүй байна. Сая Энхбаяр гишүүн бас мэдэж байна гээд л байх шиг байна. Би бол нэг их мэдэж байгаа ч юм алга. Үнэндээ бол зүгээр энэ улс төрийн намууд маань үтэр түргэн цэвэршээсэй л гэсэн ийм л хүсэл зорилгоор нэг ч гэсэн заалтыг нь хурдан биелүүлж, хэрэгжүүлж тэр дүрэм, журамдаа өөрчлөлт оруулж оруулж, шинэчлэгдэж, тэгээд авдаг мөнгө төгрөг байдаг бол авч, тэр аягүй сайн заалт орсон шүү дээ судалгаа хийх ёстой энэ тэр гээд. Тинк танк байх ёстой энэ тэр гээд.

Тэгээд тийм тийм ажлуудыгаа эрчимтэй хэрэгжүүлэхийн тулд энэ хуулийн энэ заалтыг хойшлуулж, өөрчлүүлмээргүй байна гэсэн саналтай байна. Тэгээд олон нийтийн санаа бодол бол ерөөсөө бүхэлдээ намуудын тэр хүсэл сонирхол дээр үндэслэх биш, эсрэгээрээ олон нийтийн санаа бодол, хүсэл сонирхлыг энэ намууд чинь хэрэгжүүлж төлөөлөх ийм бараг үндсэн үүрэгтэй.

Тэгэхээр энэ олон нийт юу гэж бодсон талаар энэ товъёг дотор юу ч байхгүй юм билээ. Олон нийт бол аль болох л энэ улс төрийн намуудыг хурдан сайжирч бодлогын нам болоосой гэж хүсэж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ хойшлуулах асуудлыг дэмжихгүй байгаа гэж харж байгаа олон нийтийг ч гэсэн. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төсөл, нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ гэж хуулийн төсөл орж ирж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн төсөл маань түрүүн бас гишүүд нэлээн ярих шиг боллоо, бас намын дарга нар ч хэллээ шүү дээ. Бусад намууд одоо тэр юу гэж нэрлэх нь хамаа алга, гудамжны гэнэ үү, юуны гэнэ вэ? Ямартай ч байсан бусад намуудаа дэмжих боломж бололцоог нь олгохын тулд энэ хугацааг хойшлуулж байгаа юм гэж энэ хууль санаачлагчаас ийм тайлбар орж ирж байгаа шүү дээ.

Энэ 2027 оны 8 сарын 1-ний өдөр гэдэгтэй холбоотойгоор бид чуулганаар хэлэлцээд, хэлэлцэх явцад хэрвээ хэлэлцэх явцад, хэлэлцэх шийдвэр гараад

ингээд хэлэлцэх явцад бид нар энэ хугацааг магадгүй ажлын хэсэг байгуулаад, эсвэл зарчмын зөрүүтэй саналаар хэлэлцэх явцад бид нар хуулийн хугацааг өөрчлөх ийм боломж, бололцоо, хэлэлцэх явцад бид нарт боломж, бололцоо гарна, тийм гарна. Ажлын хэсэг ч байгуулж болно. Бусад гишүүдийн өөрсдийн саналыг, бусад намуудын саналыг үндэслээд оруулж ирэх ийм бололцоо ч гарч ирэх.

Өнөөдрийн хуралдаанд бид нар Монголын социал демократ намын төлөөлөл Ж.Сундуйжав, Эх орончдын нэгдсэн намын дарга Г.Ганбат, Гэр хорооллын хөгжлийн намын Б.Батсүх, Шинэ намын дарга Гантулга, Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайхан гээд, Иргэний зориг намын Нарийн бичгийн дарга Мөнхжаргал гэх мэтчилэн бүх энэ төлөөллийг, намуудын төлөөллийг оруулж ирж ингэж яг бодит байдал дээр үүсээд байгаа нөхцөл байдлыг сонслоо.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, санал хэлж дууслаа.

Жаргалсайхан дарга та хангалттай сайн хэллээ. Тэгээд бид нар бас бүх асуудлуудыг чинь сайхан сонслоо. Тэгээд хэлэлцэх эсэх асуудлаа бид нар санал хураалт өгөөд явуулъя.

Тийм, хэлэлцэх явцдаа хэдүүлээ саналуудаа гаргачихъя. Протокол дотор, протокол дотор, протокол дотор Пүрэвдорж гишүүн саналыг хэлэлцэх явцад хугацааг хэлэлцье гэсэн ийм санал оруулсан гэдгийг протоколд оруулчихъя гэж.

Ингээд Байнгын хорооны санал хураалт явуулъя. Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

18 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 83.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Болормаа гишүүн танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.21 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

